

Хойд Атлантын эвсэл ба Оросын зөрчилдөөн юунд хвргэх вэ?

Бичсэн тууш

2017 оны 10-р сарын 20, Баасан гариг, 11:36



Оноо цагийн Орос болон барууны ертөнцийн харилцааг чухам хэрхэн нэрлэвэл зохилтой вэ? Хүйтэн дайн гэхvv? Эсвэл оороор юу гэж хэлбэл болмоор юм бэ дээ. Ер ямар ч байсан эргэлзээгvй нэг зvйл гэвэл Зовлолт холбоот улс задарсны дараанаас буюу 1991 оны хэрэг явдлаас хойш Орос болон барууны харилцаа хамгийн доод тvвшиндээ хvрсэн.

Хойд Атлантын эвсэл ба Оросын зөрчилдөөн юунд хүргэх вэ?

Бичсэн turuu

2017 оны 10-р сарын 20, Баасан гариг, 11:36

АНУ болон Оросын харилцааг сайжруулах бодолтой байгаагаа еронхийлогч Дональд Трамп амалсан нь баримттай зүйл бөгөөд энэ нь хоёр талын улс төрийн харилцаанд нааштай эерэг найдварыг торvvлж байв. Гэвч “Америкийн сонгуульд Орос хутгалдан оролцсон” гэх цуу, гvтгэлэг болоод АНУ-ын зvгээс Сири дэх Башир Асадын дэглэмд пуужингийн цохилт огсон тvрэмгий ажиллагааны улмаас энэ найдвар тасалдаж орхив. Трампын оодрог хандлагад тээг саад болж, Оростой харилцах харилцааг нь vл итгэх, гутранги хандлагатай болгож эргvvлсэн этгээдvvд бол Америкийн Батлан хамгаалах яамны сайд Джеймс Мэттиса, vндэсний аюулгvй байдлын зовлох Герберт Макмастера нар юм. Тэднээс улбаатай энэхvv vл итгэсэн хvйтэн хандлага нь Орос, НАТО-гийн хооронд бараг шууд морголдооний байдлыг ч буй болгохыг vгvйсгэмгvй байна гэсэн ажиглалтыг барууны шинжээч Бечев хийсэн байна.

Гадаадын хэвлэлvvдэд хаа сайгvй л Оросын зэвсэгт хvчин болоод эвслийн хvчний давуу байдлын тухай сэдвийг хондож бичиж байна. НАТО Оросын дорнот хил рvv анхаарлаа хандуулж, тийшээ хvч товлорvvлэхийг хичээж байгаа нь энэ асуудлын хvрээнд vvссэн бэртэгчин маягийн зальхай буруу хандлагын нэг илэрхийлэл. Энд хурц морголдоон vvсэх учиргvй л дээ, алсдаа ч гэсэн адил. Оноодор Орос хvчтэй байна. Чухам ийм учраас л Хойт атлантын эвсэлийнхэн Оросын хил рvv цэрэг зэвсгийн дэд бvтцээ ойртуулан байршуулах, нэг ёсны хариу арга хэмжээ авахад улайрч байгаа нь зайлшгvй.Â Оросын еронхийлогч Владимир Путин нэгэнтээ пост зовлолтийн орнуудын аюулгvй байдлыг хамгаалах, харилцан туслалцаа нягтралыг бэхжvvлэх гэрээний хvрээнд “цэцэгт хувьсгал”-д ямар ч vнээр хамаагvй няцаалт огно гэдгээ мэдэгдсэн,

(
эдгээр орнуудад Армен, Белорус, Казакстан, Кыргызстан, Тажикстан орж байгаа юм
)

. Яаж тэр вэ гэвэл Орос улс одгоо барууны хил залгаа болон хилийн ойролцоох улс орнуудтай хэлэлцээ vvсгэхэд бэлэн байгаа, гагцхvv энэ нь барууныхны сонирхлын гадна vлдэх нь магадтай тул нэлээд тууштай ажиллагаа шаардагдах биз. НАТО Оросын хил рvv мярааж, гэтэж байгаа нь ихээхэн эрсдэлтэй алхам юм. ОХУ-ын еронхийлогч vvнийг тодорхой ойлгож байгаа бөгөөд хэрвээ ЕвроПРО

(
Европын пуужингаас эсэргvvцэн хамгаалах систем
)

Оросын цомийн хvчин чадлыг бууруулахад бvх анхаарлаа чиглvvлж байгаа бол тvvнийгÂÂ чанаржуулах хувилбаруудаар “хариу бэлэг” барих боломжууд бэлхнээ бий.Â

Барууны шинжээчид энэ тухай бултаж, булзалгvйгээр шууд мэдэгдэж байгааг хэвлэл мэдээллээс vзэж болно. Эндээс экспертvvдэд тодорхой болсон нэг асуудал гэвэл Орос барууны нолооний хvрээнээс тусдаа ангид байгаа нь ойлгомжтой хийгээд энэ нь ухаандаа “тун сэтгэл зовоом, харамсам асуудал” ажээ. Яагаад тэр билээ? Тэдний санаагаар бол “Оросын тvрэмгийллийн золиос” болж буй Балтийн гурван улсыг хамгаалах” гэдэг зохиомол халхавч байх ёстой аж. Энэ бол тэдгээрийг хамаатуулан

Хойд Атлантын эвсэл ба Оросын зөрчилдөөн юунд хүргэх вэ?

Бичсэн туруу

2017 оны 10-р сарын 20, Баасан гариг, 11:36

“эзлэх” гэсэн 1940 оны гаж, овчтэй санаархалаас улбаатай зүйл. Одоо тэгвэл Крымын орос хэлтэн ард түмнүүд (улс орнууд) тухайлбал Эстони, Латвид тулгарсаар буй “аюул занал - тулгамдсан асуудал” бол үүний бас нэг жишиг юм. Эдгээр орнуудын эвсэлд багтах шийдвэрийг НАТО ихэд сайшаан хохивлснийг гайхах зүйлгүй. Учир нь энэ явдал Оросын зах нутаг руу хаяагаа тэлж шилжих нэг баталгаа болж буй хэрэг. НАТО -гийн боловсруулсан толовлогоо нь зовхон эдгээр улс орнууд руу нолоогоо шилжүүлэх, давж алхах тодийгоор зогсохгүй, цаашид Орос руу түрэмгийлэх далд санаа агуулж байж болзошгүй шинж байдал ч илэрч буй. Юу гэвэл тэд Польшид бүлэг батальон оруулан байршуулав, улмаар 4000 хүний бүрэлдэхүүнтэй цэргийн хэсгүүдийг эвслийн гишүүн арванзургаан улс оронд байршуулсан нь тун ноцтой асуудал. Германы зүгээс Литвэд, Канадаас Латви улсад, Их Британи Эстонид, АНУ Польшид тус тус цэргийн хүчээ товлорүүлж байна. Зэрэгцээд Варшавт болдог НАТО-гийн орнуудын дээд хэмжээний уулзалтаас хамтын ажиллагааны суурийг бэхжүүлэх гэсэн нэрийдлээр Румынд олон улсын баригад гэгчийг ногоон гэрлээр оруулахаар шийдсэн ба үүнд Польш, Болгар, Турк, Канад, АНУ, Нидерланд, Германи хамрагдаж байна.

Хойд Атлантын эвсэл ба Оросын зөрчилдөөн юунд хвргэх вэ?

Бичсэн турш

2017 оны 10-р сарын 20, Баасан гариг, 11:36



Хойд Атлантын эвсэл ба Оросын зөрчилдөөн юунд хүргэх вэ?

Бичсэн туруу

2017 оны 10-р сарын 20, Баасан гариг, 11:36

